ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-02-09 № 12

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.АМГАЛАНЖАРГАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Үндсэн хөрөнгө 653.6 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд төсвийн хөрөнгөөр 8.0 сая төгрөг, хандив тусламж бусад эх үүсвэрээр ирсэн 37.0 сая төгрөг, аймаг сумын ОНХС болон бусад эх үүсвэрээр бэлтгэгдсэн 595.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, барилга, түүнд хийсэн их засварын ажлын сайжруулалтыг бүртгэж, хөрөнгийг хүлээн авсан;

Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 09 дүгээр тогтоолоор Ирмүүн түшиг ХХК-ны дулааны эрчим хүчний үнэ тарифыг нэмж батласнаас 2.6 сая төгрөгийн халаалтын өглөг үүссэн;

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2023 оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс төрийн албаны үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 1.4 дахин өссөн.

Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

0020240030

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын нь 1 хөтөлбөр, 9 арга хэмжээний гүйцэтгэл 96.2 хувьтай, байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 18 зорилт, 89 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажилласнаар Өндөршил сумын Засаг дарга гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 87.1 хувиар үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ДУА-2024/41/НА-СТА-ТШЗ


Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2024 он

Дарга,тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**......3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**......5
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**......12
**4. АУДИТЫН ТАЙЛАН**......15
**4.1 Ерөнхий зүйл**......15
**4.2 Материаллаг байдал**......16
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**......16
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**......16
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**......16
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**......16
**4.5.1 Завсрын аудитын талаар**......16
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**......17
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**......17
**5.1 Төлбөрийн акт**......17
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
[illegible]

2024-02-09 № 12

таны ______ -ны № ______ -т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.АМГАЛАНЖАРГАЛ ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Үндсэн хөрөнгө 653.6 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд төсвийн хөрөнгөөр 8.0 сая төгрөг, хандив тусламж бусад эх үүсвэрээр ирсэн 37.0 сая төгрөг, аймаг сумын ОНХС болон бусад эх үүсвэрээр бэлтгэгдсэн 595.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, барилга, түүнд хийсэн их засварын ажлын сайжруулалтыг бүртгэж, хөрөнгийг хүлээн авсан;

Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 09 дүгээр тогтоолоор Ирмүүн түшиг ХХК-ны дулааны эрчим хүчний үнэ тарифыг нэмж баталснаас 2.6 сая төгрөгийн халаалтын өглөг үүссэн;

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2023 оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс төрийн албаны үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 1.4 дахин өссөн.

Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын нь 1 хөтөлбөр, 9 арга хэмжээний гүйцэтгэл 96.2 хувьтай, байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 18 зорилт, 89 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажилласнаар Өндөршил сумын Засаг дарга гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 87.1 хувиар үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшинийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийллэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **294,546,691.86** | **314,002,353.62** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 3,442,285.79 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 3,442,285.79 |
| **3121** | **Төгрөг** | - | 3,442,285.79 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | - | 3,442,285.79 |
| **33** | **АВЛАГА** | - | 170,390.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 170,390.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 294,546,691.86 | 310,389,677.83 |
| **354** | **Хангамжийн материал** | 292,706,691.86 | 308,549,677.83 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,790,400.00 | 1,790,400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 45,151,291.86 | 59,304,277.83 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 1,690,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 245,765,000.00 | 245,765,000.00 |
| 35600 | Мал амьтад | 1,840,000.00 | 1,840,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,322,186,727.48** | **1,748,609,024.38** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,322,186,727.48 | 1,748,609,024.38 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,307,361,727.56 | 1,729,588,784.95 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,164,285,449.09 | 1,636,764,754.79 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (311,372,853.71) | (379,061,817.73) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 161,041,130.00 | 247,463,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (45,564,575.49) | (102,138,388.99) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 314,093,261.84 | 351,757,579.14 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (64,016,506.80) | (103,447,242.79) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 79,777,804.86 | 68,904,849.86 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (41,637,815.66) | (44,880,483.30) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 59,850,000.00 | 67,659,950.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (9,094,166.57) | (13,433,416.03) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 14,824,999.92 | 19,020,239.43 |
| 39301 | Програм хангамж | 770,000.00 | 5,556,625.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (385,000.08) | (976,385.57) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 14,440,000.00 | 14,440,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,616,733,419.34** | **2,062,611,378.00** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **2,819,525.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 2,819,525.00 |
| **413** | **Өглөг** | - | 2,819,525.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 267,890.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 2,551,635.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,616,733,419.34** | **2,059,791,853.00** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,616,733,419.34 | 2,059,791,853.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 263,377,134.26 | 263,377,134.26 |
| 51101 | Өмч: - төрийн | 263,377,134.26 | 263,377,134.26 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,064,263,808.18 | 1,507,322,241.84 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,064,263,808.18 | 1,064,263,808.18 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 443,058,433.66 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 289,092,476.90 | 289,092,476.90 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,616,733,419.34** | **2,062,611,378.00** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **903,638,002.15** | **1,202,313,316.76** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **500,382,715.40** | **665,898,707.79** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 500,382,715.40 | 665,898,707.79 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 500,382,715.40 | 665,898,707.79 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 4,032,285.79 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 500,382,715.40 | 661,866,422.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **403,255,286.75** | **536,414,608.97** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 34,307,686.75 | 19,377,208.97 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,341,600.00 | 10,375,876.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 22,966,086.75 | 9,001,332.97 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 368,947,600.00 | 517,037,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 368,947,600.00 | 517,037,400.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **610,726,120.74** | **755,907,256.77** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **610,726,120.74** | **755,907,256.77** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 563,245,793.05 | 725,029,578.33 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 191,716,393.93 | 276,942,619.80 |
| 210101 | Үндсэн цалин | 147,208,653.79 | 197,457,776.67 |
| 210102 | Нэмэгдэл | 37,682,300.00 | 66,600,869.28 |
| 210104 | Урамшуулал | 6,825,440.14 | 12,883,973.85 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23,768,136.33 | 34,516,944.23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,269,757.09 | 23,486,846.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,914,525.83 | 2,763,224.19 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,531,620.72 | 2,210,579.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 350,735.80 | 529,844.83 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,701,496.89 | 5,526,448.72 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27,816,269.77 | 34,687,861.50 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,014,995.77 | 3,159,326.50 |
| 210302 | Түлш, халаалт | 24,010,874.00 | 31,328,535.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 790,400.00 | 200,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 30,058,440.75 | 34,762,571.03 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,747,130.00 | 4,308,960.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,229,600.00 | 22,051,761.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,962,386.72 | 2,583,170.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,440,000.00 | 1,239,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 730,000.00 | 2,079,510.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 6,949,324.03 | 2,500,170.03 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 1,226,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 1,226,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,015,120.00 | 13,578,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,015,120.00 | 13,578,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,628,000.00 | 13,500,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,628,000.00 | 13,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,970,718.34 | 18,837,239.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,091,530.34 | 17,448,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 238,800.00 | 473,415.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 197,372.00 | 197,372.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 505,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 104,016.00 | 146,952.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 249,272,713.93 | 296,977,842.77 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,285,540.00 | 70,525,260.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,474,000.00 | 2,625,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 202,513,173.93 | 223,827,582.77 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 47,480,327.69 | 30,877,678.44 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 36,125,600.00 | 15,882,100.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | - | 3,000,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 21,617,600.00 | 5,400,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 13,888,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 620,000.00 | 7,482,100.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 11,354,727.69 | 14,995,578.44 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,354,727.69 | 14,995,578.44 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **292,911,881.41** | **446,406,059.99** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 46,577,042.13 | 3,347,626.33 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 3,312,042.13 | 3,347,626.33 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 43,265,000.00 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (46,577,042.13) | (3,347,626.33) |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | **246,334,839.28** | **443,058,433.66** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **405,307,336.75** | **540,446,894.76** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,052,050.00** | **4,032,285.79** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,052,050.00 | 4,032,285.79 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2,052,050.00 | 4,032,285.79 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,052,050.00 | 3,000,000.00 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | - | 1,032,285.79 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **403,255,286.75** | **536,414,608.97** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 34,307,686.75 | 19,377,208.97 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,341,600.00 | 10,375,876.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 22,966,086.75 | 9,001,332.97 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 368,947,600.00 | 517,037,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 368,947,600.00 | 517,037,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **405,307,336.75** | **529,004,608.97** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **405,307,336.75** | **529,004,608.97** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **354,103,295.09** | **498,224,430.53** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 191,748,698.28 | 276,942,619.80 |
| 210101 | Үндсэн цалин | 147,240,958.14 | 197,457,776.67 |
| 210102 | Нэмэгдэл | 37,682,300.00 | 66,600,869.28 |
| 210104 | Урамшуулал | 6,825,440.14 | 12,883,973.85 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23,735,831.98 | 34,516,944.23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,251,626.71 | 23,486,846.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,911,774.09 | 2,763,224.19 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,529,764.85 | 2,210,579.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 346,308.99 | 529,844.83 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,696,357.34 | 5,526,448.72 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 27,816,269.77 | 32,136,226.50 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,014,995.77 | 3,159,326.50 |
| 210302 | Түлш, халаалт | 24,010,874.00 | 28,776,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 790,400.00 | 200,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23,109,116.72 | 32,646,641.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,747,130.00 | 4,268,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,229,600.00 | 22,051,761.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,962,386.72 | 2,583,170.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,440,000.00 | 1,239,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 730,000.00 | 2,504,010.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 1,226,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 1,226,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,015,120.00 | 13,578,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,015,120.00 | 13,578,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9,628,000.00 | 13,500,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,628,000.00 | 13,500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,970,718.34 | 18,837,239.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,091,530.34 | 17,448,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 238,800.00 | 473,415.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 197,372.00 | 197,372.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 505,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 104,016.00 | 146,952.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 47,079,540.00 | 74,840,260.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,605,540.00 | 72,215,260.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,474,000.00 | 2,625,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **51,204,041.66** | **30,780,178.44** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 36,125,600.00 | 15,784,600.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | - | 3,000,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 21,617,600.00 | 5,400,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 13,888,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 620,000.00 | 7,384,600.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 15,078,441.66 | 14,995,578.44 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,354,727.69 | 12,490,968.57 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 3,723,713.97 | 2,504,609.87 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **3,723,713.97** | **11,442,285.79** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | - | **8,000,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | **8,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 8,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 8,000,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | = | **(8,000,000.00)** |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | = | = |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 3,723,713.97 | 3,442,285.79 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 3,442,285.79 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 263,377,134.26 | 289,092,476.90 | 821,652,682.87 | 1,374,122,294.03 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **263,377,134.26** | **289,092,476.90** | **821,652,682.87** | 1,374,122,294.03 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 242,611,125.31 | 242,611,125.31 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **263,377,134.26** | **289,092,476.90** | **1,064,263,808.18** | 1,616,733,419.34 |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **263,377,134.26** | **289,092,476.90** | **1,064,263,808.18** | 1,616,733,419.34 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **263,377,134.26** | **289,092,476.90** | **1,064,263,808.18** | 1,616,733,419.34 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 443,058,433.66 | 443,058,433.66 |
| D09 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **263,377,134.26** | **289,092,476.90** | **1,507,322,241.84** | 2,059,791,853.00 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 524,288,400.00 | 504,546,431.43 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 524,288,400.00 | 504,546,431.43 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 509,838,400.00 | 491,330,931.43 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 278,933,300.00 | 276,942,619.80 |
| 210101 | Үндсэн цалин | 198,853,100.00 | 197,457,776.67 |
| 210102 | Нэмэгдэл | 68,180,200.00 | 66,600,869.28 |
| 210104 | Урамшуулал | 11,900,000.00 | 12,883,973.85 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35,054,200.00 | 34,516,944.23 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,813,900.00 | 23,486,846.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,816,300.00 | 2,763,224.19 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,243,100.00 | 2,210,579.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 548,200.00 | 529,844.83 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,632,700.00 | 5,526,448.72 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 31,476,900.00 | 30,680,603.40 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,500,000.00 | 1,703,703.40 |
| 210302 | Түлш, халаалт | 28,776,900.00 | 28,776,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 200,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 39,086,000.00 | 31,263,265.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,100,000.00 | 4,098,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,966,000.00 | 21,109,385.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,830,000.00 | 2,433,170.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,800,000.00 | 1,239,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,390,000.00 | 2,383,010.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 650,000.00 | 650,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 650,000.00 | 650,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 21,140,000.00 | 21,093,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,000,000.00 | 8,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,140,000.00 | 13,093,500.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 12,245,000.00 | 12,240,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,245,000.00 | 12,240,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,353,000.00 | 9,693,739.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,176,000.00 | 8,305,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 684,000.00 | 473,415.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 373,000.00 | 197,372.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 148,000.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 600,000.00 | 505,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 372,000.00 | 146,952.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 79,900,000.00 | 74,250,260.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 77,275,000.00 | 71,625,260.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,625,000.00 | 2,625,000.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 14,450,000.00 | 13,215,500.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 14,450,000.00 | 13,215,500.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,300,000.00 | 5,400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,150,000.00 | 4,815,500.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 524,288,400.00 | 504,546,431.43 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 524,288,400.00 | 504,546,431.43 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 524,288,400.00 | 504,546,431.43 |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| 5 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **16,872,599.10** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **16,872,599.10** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **14,303,499.10** |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,455,623.10** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,455,623.10 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,383,376.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 170,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 942,376.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 150,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 121,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **576,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 576,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **485,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 485,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,260,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,260,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,143,500.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,143,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,569,100.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,569,100.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,569,100.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **19,377,208.97** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **19,377,208.97** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,375,876.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 9,001,332.97 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газар нь эрхэм зорилгоо "Сумын тогтвортой хөгжлийг хангах үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд нь Засаг даргад бүх талын

дэмжлэг үзүүлэх, гаргасан шийдвэрийнх нь биелэлтийг хангуулах, нутгийн захиргааны манлайллыг дээшлүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх, үр дүнд чиглэсэн удирдлагын тогтолцоо бүхий цомхон чадварлаг алба байхад оршино." гэж тодорхойлжээ.

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг хуулиудад өөрчлөлт ороогүй. Харин төрийн албан хаагчдын цалин хөлстэй холбоотой дараах тогтоолуудад өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалт"-ыг шинэчлэн тайлант оноос дагаж мөрдөхөөр,
- Засгийн газрын "Журам батлах тухай" 2018 оны 382 дугаар тогтоолын нэмэлт өөрчлөлтүүд,
- Засгийн газрын 2023 оны 240 дугаар тогтоолоор "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай"
- Засгийн газрын 2023 оны 241 дугаар тогтоолоор "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын нэгжгүй, дотоод аудитыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хийдэг бөгөөд тайлант онд албанаас хийсэн хяналт, шалгалтаар алдаа зөрчил илрээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 онд шинэчлэн байгууллагын даргын тушаалаар батлан үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 445,878.0 мянган төгрөгөөр буюу 27.6 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 294,546.7 | 314,002.4 | 19,455.7 |

| | | | |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 3,442.3 | 3,442.3 |
| Авлага | 0.00 | 170.4 | 170.4 |
| Бараа материал | 294.546.7 | 310,389.7 | 15,843.0 |
| Үндсэн хөрөнгө | 1,322,186.7 | 1,748,609.0 | 426,422.3 |
| Нийт хөрөнгийн дүн | 1,616,733.4 | 2,062,611.4 | 445,878.0 |
| Нийт өр төлбөр | - | - | 0.00 |
| Цэвэр хөрөнгө өмчийн дүн | 1,616,733.4 | 2,059,791.9 | 443,058.4 |
| Засгийн газрын хувь оролцоо | 1,616,733.4 | 2,059,791.9 | 443,058.4 |
| Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн | 1,616,733.4 | 2,059,791.9 | 443,058.4 |

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 3,442.3 мянган төгрөг байгаа нь Ахмадын сангийн тайлант оны дансны үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Авлагын үлдэгдэл 170.4 мянган төгрөг нь цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн шийтгэлийн зардлыг буруу тооцоолж илүү шилжүүлсэнтэй холбоотой байна. Өр төлбөрийн үлдэгдэл 2,819.5 мянган төгрөгийн өглөгийн 267.9 мянган төгрөгийн өр нь цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн шийтгэлийн зардлыг буруу тооцоолж дутуу шилжүүлсэнтэй холбоотой, 267.9 мянган төгрөгийн өр нь халаалтын зардлын үнийн өсөлтөөс шалтгаалж үүссэн өглөг байна.

Бараа материал дансны үлдэгдэл 310,389.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 15,843.0 мянган төгрөгөөр өссөн нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд үнэ төлбөргүй ирсэн аж ахуйн материалын өсөлттэй холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 8,000.0 мянган төгрөг, хандив тусламж бусад эх үүсвэрээр ирсэн 37,000.0 мянган төгрөг, аймаг сумын ОНХС болон бусад эх үүсвэрээр бэлтгэгдсэн 595,797.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, барилга, түүнд хийсэн их засварын ажлын сайжруулалтыг бүртгэж 55,308.4 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж, 223,827.6 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцсон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,059,791.9 мянган төгрөг болж 443,058.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 584,397.3 мянган төгрөг, нийт зарлагыг 584,397.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас анх 161,346.8 мянган төгрөгөөр бууруулж, 423.050.5 мянган төгрөгөөр баталсан боловч 2023 оны төсвийн тодотголоор 101,237.9 мянган төгрөг нэмэгдүүлж 524,288.4 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн саналыг бууруулж баталсан нь харьяа дээд газраас тогтмол зардлууд болон урсгал зардлуудыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу өмнөх оны төсвийн дүнгээр болгосонтой, харин төсвийг 23.9 хувиар нэмэгдүүлсэн нь цалингийн зардлыг нэмэгдлийн зөрүүгээр нэмэгдүүлж өгсөнтэй тус тус холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 524,288.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс төлөвлөгөөт санхүүжилтийн 98.6 хувь буюу 517,037.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 7,251.0 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 504,546.4 мянган төгрөг буюу 96.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 3,995.6 мянга, нийтлэг үйлчилгээний зардлыг 2,396.2 мянга, орон нутгийн нөөц хөрөнгийг 4,547.1 мянга, хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх зардлыг 7,250.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна. Төсвийн хэмнэлт 12,491.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 70106 - Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | 524,288.4 | 504,546.4 | 19,742.0 | 96.2 |
| 2 | 80101 – Үндсэн үйл ажиллагааны зардал | 300,767.6 | 296,772.2 | 3,995.4 | 98.7 |
| 3 | 80106 - Баг хорооны үйл ажиллагааны зардал | 54,225.5 | 53,934.7 | 290.8 | 99.5 |
| 4 | 80112 - Нийтлэг үйлчилгээ | 71,020.3 | 68,624.1 | 2,396.2 | 96.6 |
| 5 | 80714 - Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт | 3,000.0 | 3,000.0 | - | 100.0 |
| 6 | 80801 – Нөхөн олговор | 6,300.0 | 5,400.0 | 900.0 | 85.7 |
| 7 | 80802 – Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 5,150.0 | 4,815.5 | 334.5 | 93.5 |
| 8 | 81102 – Орон нутгийн нөөц хөрөнгө | 69,525.0 | 64,950.9 | 4,574.1 | 93.4 |
| 9 | 82212 – Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх | 9,300.0 | 2,049.0 | 7,251.0 | 22.0 |
| 10 | 82801 – Улсын их баяр наадам | 5,000.0 | 5,000.0 | - | 100.0 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 10,375.9 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 9,001.3 мянга, нийт 19,377.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлснийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 1,455.6 мянга, хангамж, бараа материалын зардалд 1,383.4 мянга, нормативт зардалд 576.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 485.0 мянга, дотоод албан томилолтын зардалд 1,260.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 9,143.5 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 2,569.1 мянган төгрөг, нийт 16,872.6 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үлдэгдэл 2,504.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэсэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Ихбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийн 01/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт хөрөнгийн дүн болох **2,062,611.4** мянган төгрөгөөс 1 хувиар буюу **20,626.1** мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тайлант онд батлагдсан төсвийн 96.2 хувийг зарцуулж, 12,491.0 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгож орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Төсвийг 96.2 хувьтай зарцуулсны дийлэнх хувь нь үндсэн үйл ажиллагаа, нийтлэг үйлчилгээ, орон нутгийн нөөц хөрөнгө, хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх зардлын төсвийг бүрэн зарцуулаагүйтэй холбоотой байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой төлөвлөсөн 34 горим сорилыг гүйцэтгэхэд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтуудыг зөрчин 1,510.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн зөрчил илэрсэн.

*Шийдвэрлэсэн: Хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.*

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 онд нийт 663,524.0 мянган төгрөгийн 165 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулахаас 110,800.2 мянган төгрөгийн 52 мэдээллийг байршуулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 78.6 хувьтай байна. Өмнөх онд тус зөрчилд хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байгаа тул зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх баталгаа мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж үзэн, зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

*Шийдвэрлэсэн: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.*

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар нийт 2,191.2 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрч, аудитын явцад 782.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,408.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, нягтлан бодох бүртгэл

хөтлөлттэй холбоотой зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн. Завсрын аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгөгдсөн төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн тухай хариуг Төрийн аудитын газарт албан бичгээр болон санхүүгийн тайлангийн аудитын **"https://fas.audit.mn/"** системээр ирүүлсэн боловч Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Иймээс төсвийн шууд захирагчид зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүллээ.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 1,525.3 | 1 | 1,525.3 | 100 |
| Албан шаардлага | 1 | 32.3 | 1 | 32.3 | 100 |
| Зөвлөмж | 1 | - | | | - |
| **Нийт дүн** | **3** | **1,163.** | **2** | **1,163.1** | **66.7** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан бараа материалын зардлын худалдан авалт, зарцуулалтын тооцооллыг шалгах горим сорилыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **17,120.6** мянган төгрөгийн зөрчил илрүүлэн аудитын явцад **782.7** мянган төгрөгийн алдааг залруулж, **1,408.5** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **11,624.3** мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, **3,305.4** мянган төгрөгийн зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

***Залруулсан алдаа:***

Аудитаар нийт **782.7** мянган төгрөгийн алдаа[1] илрүүлснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Цалингийн хүснэгтээр тооцоолсон нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын тайланд зөрүүтэй тайлагнасан.

*Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан*

***Залруулагдаагүй алдаа:***

Аудитаар нийт 16,338.2 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 1,408.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, Төрийн хэмнэлт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийг арилгуулах 14,929.7 мянган төгрөгийн 5 албан шаардлага, 3,305.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн.

### 5.1 Төлбөрийн акт

1. Орон сууцны түрээсийн орлогыг **1,408,500.00** */Нэг сая дөрвөн зуун найман мянга таван зуун/* төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн.

Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.2.1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах/, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн "Түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай" 2020 оны 08 тоот тогтоолын хавсралтаар баталсан

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажиллагч бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**"Орон нутгийн өөрийн өмчийн гэрээний үлгэрчилсэн загвар"**-ын дагуу түрээслэгчтэй байгуулсан 01-3 дугаартай гэрээний 3.4- т /Түрээслэгч нь түрээсийн сарын төлбөр болох...........(тоо, үсгээр бичих) төгрөгийг тухайн сарын 25-ны өдрийн дотор түрээслүүлэгчийн дансанд шилжүүлнэ./, **5.11.-т** /Түрээслүүлэгч нь түрээсийн төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу төлөөгүй бол энэхүү гэрээнд заасан алданги ногдуулж, төлүүлэх эрхтэй./ **6.8.-д** /Түрээсийн төлбөр болон ашиглалтын зардлыг энэхүү гэрээнд заасны дагуу төлөх үүрэгтэй./ заасныг тус тус зөрчсөн байна.

**5.2 Албан шаардлага**

1. **Хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг чанаргүй хийж санхүүгийн тайланд бараа материалын тооллогын дүнг зөрүүтэй тайлагнаж, тооцоог бодож баталгаажуулаагүй.**

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т /Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т /Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг тус тус зөрчсөн.

2. **Цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй бусад этгээдээс 1,510,000.00** /Нэг сая таван зуун арван мянга/ **төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авсан.**

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.13. /Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно./, 48 дугаар зүйлийн 48.5. /Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ./ Төрийн хэмнэлтийн хуулийн 14 дүгээр зүйл 14.4. /Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно/ заасныг тус тус зөрчсөн;

3. **Байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж байгаа 3 авто машинд зарцуулсан 4,955,325.00** /Дөрвөн сая есөн зуун тавин таван мянга гурваг зуун хорин таван/ **төгрөгийн тээвэр шатахууныг хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог хууль журмын дагуу бодож баталгаажуулаагүй.**

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 зүйлийн 16.5.2 /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. /Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат, дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна/, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1-р хавсралт /Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг үндэслэн тогтоож, мөрдөж ажиллах, шатахууны зарцуулалтын тооцоог тогтсон хугацаанд бодож, тооцоо бодсон актыг үйлдэж баталгаажуулах/ дахь заалтыг тус тус зөрчсөн;

4. **Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5.2 сая төгрөгийн зарлагын 1 мөнгөн гүйлгээ , төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 105.5 сая төгрөгийн 51 шийдвэрийг мэдээлээгүй.**

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн /Шилэн дансны зарчим/ 4.1.1-д /мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх:/, /Шилэн дансны зарчим/ 4.1.3-т /тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; /, 6 дугаар зүйлийн 6.4-т /Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:/, 6.4.5-д /цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;/, 6.4.8-д /бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;/, 7.2 -т /Энэ хуулийн 7.1-д заасан эрх бүхий

албан тушаалтан мэдээлэх үүргээ бусдад шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй./ заасныг тус тус зөрчсөн;

5. **Төсвийн хөрөнгөөр худалдан авсан зарим төрлийн бараа материалын орлогыг бараа материалын шинж чанар, анхан шатны баримт, худалдан авсан төсвийн зардлын ангиллыг харгалзахгүй данс зөрүүлэн бүртгэж, бараа материалыг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан 5,159.000.00 /Таван сая нэг зуун тавин есөн мянга/ төгрөгийг зарцуулсан байна.**

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 -д /Үнэн зөв байх/ , 13 дугаар зүйлийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./, 20 дугаар зүйлийн 20.2.4. /нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах:/-т, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан **“Маягт, заавар батлах тухай”** зааврын **5.-д** /Бараа, материалын хөдөлгөөн, үлдэгдлийн тоо хэмжээг тухай бүрд мэдэх, түүний бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор агуулахын бүртгэлийг эд хариуцагч материалын нэр төрөл, зэрэг, дугаар бүр дээр нээж хөтөлнө./, **6-д** /Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн "Шаардах хуудас"-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ./ заасныг тус тус зөрчсөн;

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Эд хариуцагч нь бараа, материалын хөдөлгөөн, үлдэгдлийн тоо хэмжээг агуулахын бүртгэлийн дэвтрээр хөтөлж баримтжуулаагүй.
Энэ нь хөрөнгөд бүртгэлээр тавих алдагдах, зориулалт бусаар зарцуулах, дутагдах эрсдэлтэй. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1.-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Маягт, заавар батлах тухай” зааврын 5.-д /Бараа, материалын хөдөлгөөн, үлдэгдлийн тоо хэмжээг тухай бүрд мэдэх, түүний бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор агуулахын бүртгэлийг эд хариуцагч материалын нэр төрөл, зэрэг, дугаар бүр дээр нээж хөтөлнө./, 6-д /Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн "Шаардах хуудас"-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ./ заасныг зөрчиж мөн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
Өгсөн зөвлөмж:
“Агуулахын бүртгэлийг 2023.10.01.-ны өдрөөс эхлэн данс бүрээр хөтөлж нотлох баримтыг 2024.01.25-өдрийн дотор ирүүлэх”

Тус зөвлөмжийг завсрын аудитаар хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийг 2024.01.17-ны өдрийн 01/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны үр дүнд бий болсон өөрийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан урсгал зардалд зарцуулсан. Энэ нь байгууллагын үндсэн үйл ажиллагааны үр дүнд бий болсон орлого хяналтгүй, үр дүнгүй урсгал зардал зарцуулагдах эрсдэлтэй.
Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.-т /Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна./, 41 дүгээр зүйлийн 41.2.-т /Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:/ , 41.2.1.-д /хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн

төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;/, 44 дүгээр зүйлийн 44.4.-д /Туслах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төсвийн жилийн дундуур авсан бол түүний төсвийг нэмэлт төсөв хэлбэрээр, бусад тохиолдолд тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ./, 44.5.-д /Туслах үйл ажиллагааны үр дүнд бий болох ашгийг дараах зүйлд зарцуулна:/, 44.5.1.-д /тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны төсвийн санхүүжилтийг бууруулах;/ заасныг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж*:
"Байгууллагын үндсэн үйл ажиллагааны үр дүнд жил бүр орох боломжтой орлогыг байгууллагын төсвийн төлөвлөгөөнд тусгаж зориулалтын дагуу зарцуулах."

Өгсөн зөвлөмжийг хуулийн хүрээнд хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар[3]т нотлох баримтын хамт ирүүлэхийг төсөв захирагчид зөвлөж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

[3] Монгол Улс, Дундговь аймаг, Сайнцагаан сум, 7 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 70593113

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цалингийн хүснэгтээр тооцоолсон нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын тайланд зөрүүтэй тайлагнасан. | 1 | 782.7 | - | - | 1 | 782.7 | 1 | 782.7 | | | | |
| **Дүн** | **1** | **782.7** | - | - | **1** | **782.7** | **1** | **782.7** | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/**

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнэлэс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Түрээсийн орлогыг дутуу төвлөрүүлсэн. | 1 | 1408.5 | 1 | 1,408.5 | | | | | | - | | |
| Эд хариуцагч нь бараа, материалын хөдөлгөөн, үлдэгдлийн тоо хэмжээг агуулахын бүртгэлийн дэвтрээр хөтөлж баримтжуулаагүй. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Хагас жилийн хөрөнгийн тооллогыг чанаргүй хийж, тооцоог бодож баталгаажуулаагүй. | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| Байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж байгаа 3 авто машинд зарцуулсан тээвэр шатахууныг хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог хууль журмын дагуу бодож баталгаажуулаагүй. | 1 | 4,955.3 | | | 1 | 4,955.3 | | | | - | | |
| Төсвийн хөрөнгөөр худалдан авсан зарим төрлийн бараа материалын орлогыг бараа материалын шинж чанар, анхан шатны баримт, худалдан авсан төсвийн зардлын ангиллыг харгалзахгүй данс зөрүүлэн бүртгэж, бараа материалыг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан. | 1 | 5,159.0 | | | 1 | 5,159.0 | | | | | | |
| Байгууллагын үндсэн үйл ажиллагааны үр дүнд бий болсон өөрийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан урсгал зардалд зарцуулсан. | 1 | 3,305.4 | | | | | 1 | 3,305.4 | | | | |
| **Нийт дүн** | 6 | **14,828.2** | 1 | **1,408.5** | 3 | **10,114.3** | 2 | **3,305.4** | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнэлгээ: Төлбөрийн акт | | Үнэлгээ: Албан шаардлага | | Үнэлгээ: Зөвлөмж | | Үнэлгээ: Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Үнэлгээ: Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5.2 сая төгрөгийн зарлагын 1 мөнгөн гүйлгээ , төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 105.5 сая төгрөгийн 51 шийдвэрийг мэдээлээгүй. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| **Дүн** | **1** | **-** | | | | | **1** | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| Цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй бусад этгээдээс тоног төхөөрөмж худалдан авсан. | 1 | 1,510.0 | | | 1 | 1,510.0 | | | | | | |
| Дүн | 1 | 1,510.0 | | | 1 | 1,510.00 | | | | | | |
| **Нийт дүн** | **2** | **1,510.0** | | | **2** | **1,510.0** | **2** | | | | | |

## ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

**Байгууллагын нэр:** Өндөршил сумын Засаг даргын Тамгын газар
**Тайлант хугацаа:** 2023 оны 4 дүгээр улирал

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын холбогдох хүний | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **Заверын аудит** | | | | | | | | | |
| 1 | Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл | Цалингийн хүснэгтээр тооцоолсон нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын тайланд зөрүүтэй тайлагнасан. | 782,721.36 | Санхүүгийн тайланд залруулга хийх | Санхүүгийн тайланд залруулга хийсэн. | Санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн | Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар залруулж тайлагнах | Дарга, Нягтлан бодогч | Б.Амгаланжаргал Х.Батжаргал |
| 2 | Өөрийн орлогын данстай холбоотой | Түрээсийн орлогыг дутуу төвлөрүүлсэн. | 1,408,500.00 | Төлбөрийн акт тогтоох | Төлбөрийн актыг хугацаанд барагдуулж нотлох баримтыг ирүүлсэн. | Түрээсийн орлогыг 2023.10.25-ны өдрийн дотор төвлөрүүлсэн. | Төлбөрийн акт тогтоосон. | Дарга, Нягтлан бодогч | Б.Амгаланжаргал Х.Батжаргал |
| 3 | Бараа материалын данстай холбоотой | Эд хариуцагч нь бараа, материалын хөдөлгөөн, үлдэгдлийн тоо хэмжээг агуулахын бүртгэлийн дэвтэрээр хөтөлж баримтжуулаагүй. | | Зөвлөмж хүргүүлэх | Зөвлөмжийг хэрэгжүүлж нотлох баримтыг ирүүлсэн. | Зөвлөмжийг хэрэгжүүлж нотлох баримтыг ирүүлсэн. | Зөвлөмж хүргүүлсэн. | Дарга, Нягтлан бодогч | Б.Амгаланжаргал Х.Батжаргал |
| 4 | Үндсэн хөрөнгийн данс | Хагас жилийн хөрөнгийн тооллогыг чанаргүй хийж, тооцоог бодож баталгаажуулаагүй. | | Албан шаардлага өгөх | Албан шаардлагыг хэрэгжүүлж нотлох баримтыг ирүүлсэн. | Албан шаардлага хэрэгжүүлж нотлох баримтыг ирүүлсэн. | Албан шаардлага өгөх | Дарга, Нягтлан бодогч | Б.Амгаланжаргал Х.Батжаргал |
| **Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит** | | | | | | | | | |
| 5 | Үндсэн хөрөнгө | Тоног төхөөрөмжийн худалдан авалтыг тус бараа нь цахим дэлгүүрт байршсан эсэхэд судалгаа хийлгүй цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй бусад этгээдээс тоног төхөөрөмж худалдан авсан. | 1,510,000.00 | Албан шаардлага хүргүүлэх | 2024 оны 02 сарын 05-ны өдөр танилцуулсан. Аудиторын саналыг хүлээн зөвшөөрсөн | Албан шаардлага хүргүүлэх | Албан шаардлага хүргүүлсэн. | Дарга, Нягтлан бодогч | Б.Амгаланжаргал Х.Батжаргал |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Тээвэр шатахуун | Байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж байгаа 3 авто машинд зарцуулсан тээвэр шатахууны хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог хууль журмын дагуу бодож баталгаажуулаагүй. | 4,955,325.00 | Албан шаардлага хүргүүлэх | 2024 оны 02 сарын 05-ны өдөр танилцуулсан. Аудиторын саналыг хүлээн зөвшөөрсөн | Албан шаардлага хүргүүлэх | Албан шаардлага хүргүүлсэн. | Дарга, Нягтлан бодогч | Б.Амгаланжаргал Х.Батжаргал |
| 7 | Шилэн дансны тухай хууль | Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5.2 сая төгрөгийн зарлагын 1 мөнгөн гүйлгээ , төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 105.5 сая төгрөгийн 51 шийдвэрийг мэдээлээгүй. | | Шилэн дансны хугацаа хоцролтын хэрэгжилт 100 хувтай болович мэдээлсэн байдлын хэрэгжилт 78.6 хувьтай байгаа тул шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх ерөнхий чиглэлийн дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн. | 2024 оны 02 сарын 05-ны өдөр танилцуулсан. Аудиторын саналыг хүлээн зөвшөөрсөн | Албан шаардлага хүргүүлэх. | Албан шаардлага хүргүүлсэн. | Дарга, Нягтлан бодогч | Б.Амгаланжаргал Х.Батжаргал |
| 8 | Бараа материалын данстай холбоотой | Бараа материалын ангиллыг зөрүүлэн бүртгэж, бараа материалыг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан. | 5,159,000.00 | Албан шаардлага хүргүүлэх | 2024 оны 02 сарын 05-ны өдөр танилцуулсан. Аудиторын саналыг хүлээн зөвшөөрсөн | Албан шаардлага хүргүүлэх | Албан шаардлага хүргүүлсэн. | Дарга, Нягтлан бодогч | Б.Амгаланжаргал Х.Батжаргал |
| 9 | Орлогын данс | Байгууллагын үндсэн үйл ажиллагааны үр дүнд бий болсон өөрийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан урсгал зардалд зарцуулсан. | 3,305,400.00 | Байгууллагын үндсэн үйл ажиллагааны үр дүнд жил бүр орох боломжтой орлогыг байгууллагын төсвийн төлөвлөгөөнд тусгаж зориулалтын дагуу зарцуулах. | 2024 оны 02 сарын 05-ны өдөр танилцуулсан. Аудиторын саналыг хүлээн зөвшөөрсөн | Зөвлөмж өгөх */Зөвлөмжийн хариуг 2024.06.25-ны өдрийн дотор нотлох баримтын хамт ирүүлэх/* | Зөвлөмж өгөх | Дарга Нягтлан бодогч | Б.Амгаланжаргал Х.Батжаргал |
| | Нийт дүн | | 17,120,946.36 | | | | | | |

Бэлтгэсэн: Ахлах аудитор Д.Ихбаяр

Хянасан: Аудитын менежер Х.Наранцацрал

Хоёр дах шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох

Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн :

Дарга Б.Амгаланжаргал

Нягтлан бодогч Х.Батжаргал